



RioTinto



МУИС
ИННОВАЦ

● СТАРТ АП
ТӨСЛҮҮД
2021 ОН



ТӨСЛИЙН НЭР: ISOPRENE - МОДНЫ ҮРТЭСНЭЭС БАЙГАЛИЙН ГАРАЛТАЙ МАШИНЫ ҮНЭРТҮҮЛЭГЧ ГАРГАН АВАХ

Төслийн удирдагч: Доктор Т.Сувдмаа
ШУС, БУС, Биологийн тэнхим

ТАНИЛЦУУЛГА:

Манай улсад борлуулагдаж буй дийлэнх үнэртүүлэгч нь органик бус, импортын бүтээгдэхүүнүүд байдаг тул бид үндэсний брэнд бүтээгдэхүүн бий болгож, дотоодын зах зээлд тодорхой байр суурь эзэлсэн, импортын барааг орлохуйц машины органик үнэртүүлэгч гарган авах зорилготой. Ургамалд үүсэж бий болдог, дэгдэмхий, үнэрт нэгдлүүд болох эфирийн тос нь анхилам, хурц үнэртэй, устай хамт хялбар нэрэгддэг ба энэхүү шинж чанар дээр үндэслэн модны хаягдал болох үртсийг эфирийн тосны түүхий эд болгон ашигласан. Манай үнэртүүлэгч нь байгалийн гаралтай, хүний биед сөрөг нөлөөгүй, бактерийн эсрэг идэвхтэй гэдгээрээ давуу талтай. Бид одоогоор бүтээгдэхүүнээ шингэн болон хагас хатуу хэлбэрээр гарган авсан байгаа бөгөөд цаашид үнэрийг илүү удаан барих тал дээр ажиллаж байна.



Бид үндэсний брэнд бүтээгдэхүүн бий болгож, дотоодын зах зээлд тодорхой байр суурь эзэлсэн, импортын барааг орлохуйц машины органик үнэртүүлэгч гарган авах зорилготой.



Судалгааны багийн гишүүд:

Б.Амаржаргал /ШУС.БУС.Биологийн тэнхим, Биотехнологи-IV/
А.Алтантуул /ШУС.БУС.Биологийн тэнхим, Биохими-IV/
Х.Идэрмөнх /ШУС.БУС.Биологийн тэнхим, Биотехнологи-IV/
Ж.Доржбат /ШУС.БУС.Биологийн тэнхим, Биохими-Магистрант/
Б.Насантогтох /ШУС.БУС.Биологийн тэнхим, Биохими-IV/



Холбоо барих мэдээлэл

МУИС, Хичээлийн байр 2-213Г

☎ 77307730 – 2490

✉ suvdmaa@num.edu.mn





ТӨСЛИЙН НЭР: ISOPRENE - СИВЕРСИЙН ШАРИЛЖ (*Artemisia sieversiana*) УРГАМЛЫН ХАНД АГУУЛСАН ЭЛЭГНИЙ ХАВДРЫН ЭСРЭГ ҮЙЛЧЛЭЛТЭЙ ЭМИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Төслийн удирдагч: Дэд профессор Б. Даваапүрэв
ХШУИС, Хими, биологийн инженерчлэлийн тэнхим

ТАНИЛЦУУЛГА:

"МОНГРИНТАКАРА" ХХК буюу Монголын ногоон эрдэнэ компани нь 2018 онд үүсгэн байгуулагдсан МУИС-ийн дэргэдэх гарааны компани юм. Бид байгалийн гаралтай эрүүл мэндийн бүтээгдэхүүний ирээдүйн хөгжлийг тодорхойлогч, шинийг санаачлагч, тэргүүлэгч, байгууллага байж, хэрэглэгчдэдээ хамгийн чанартай, шинжлэх ухаанч мэдлэг шингэсэн, шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэнэ. Манай компани нь "Uniqare" ам зайлагч бэлдмэл болон түүний цуврал бүтээгдэхүүн болох "Антипи" хоолойны махны үрвэсэл дарах хүлхмэл, элэгний үрэвслийг амчлах, элэг хамгаалах "LIVEPRO" ам болон "Хөөрөл" шарталтын эсрэг бэлдмэлийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн судалгааг амжилттай хийн зах зээлд нэвтрүүлэх шатандаа явж байна. Start-up 2021 хөтөлбөрт манай компани нь "LIVE-PRO" элэг хамгаалах эмийн цуврал элэгний хавдрын эсрэг үйлчилгээтэй "Antican" эмийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн судалгааг хийж байна.



Бид байгалийн гаралтай эрүүл мэндийн бүтээгдэхүүний ирээдүйн хөгжлийг тодорхойлогч, шинийг санаачлагч, тэргүүлэгч, байгууллага байж, хэрэглэгчдэдээ хамгийн чанартай, шинжлэх ухаанч мэдлэг шингэсэн, шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэнэ.



Судалгааны багийн гишүүд:

Д.Энхтуул ХШУИС-Био инженерчлэл, Магистрант-2
О.Ундармаа ХШУИС-Био инженерчлэл, Магистрант-2
М.Номуундарь ХШУИС-Био инженерчлэл, Магистрант-2
Т.Цэнгүүн ХШУИС-Био инженерчлэл, Магистрант-2
Б.Батцэцэг ХШУИС-Био инженерчлэл, Магистрант-2
Б.Бүжэн ХШУИС-Био инженерчлэл, Магистрант-1
Д.Эрдэнэтуул ХШУИС-Био инженерчлэл, Магистрант-1
Б.Цагаандорж БС, Бакалавр-4
Ү.Батмагнай БС-Санхүү, Магистрант-1
Э.Бүрэнжаргал Itzone LLC, Novelsoft LLC, Санхүүгийн шинжээч



Холбоо барих мэдээлэл

МУИС, Номын сан 506 тоот

73707730 - 3212

davaapurev@seas.num.edu.mn

Lactica

Love your health.

ТӨСЛИЙН НЭР: “БИОЖЕЛЛИ” ПРОБИОТИК ЭРҮҮЛ МЭНДИЙН УНДАА


Төслийн удирдагч: Доктор Г.Оюундэлгэр
ШУС, БУС, Биологийн тэнхим

ТАНИЛЦУУЛГА:

Лактика баг нь хүний биед ашигтай сүүн хүчлийн бактерийг желлитэй өтгөн ундаа болгохоор ажиллаж байна. Бусад импортын бүтээгдэхүүнүүдтэй жишихэд манай бүтээгдэхүүн пробиотик бактери агуулдгаараа давуу талтай юм. Антибиотик эмчилгээ хийлгэж байгаа, суурьшмал амьдралд дассан хүмүүсийн гэдэсний хэвийн бичил биетний хэмжээ энгийн хүнийхээс бага байдаг тул сүү, цагаан идээ хэрэглэж чадахгүй байх, дархлаа сулрах, витаминь дутагдалд орох эрсдэлтэй байдаг. Энэхүү ундаа нь нүүдалчин соёлын баталгаа болох монгол орны шилмэл айргаас хөрөнгөлөн авсан бактерийг орчин үеийн технологиор хүний биеийн ашигтай бичил биетнийг хангах үйлчилгээтэй тул дээрх асуудлаас гадна жингээ барих, дархлаа сайжруулах, витаминь хэрэгцээг хангах хүсэлтэй хүмүүст төгс зохицсон бүтээгдэхүүн болно.



Бусад импортын бүтээгдэхүүнүүдтэй жишихэд манай бүтээгдэхүүн пробиотик бактери агуулдгаараа давуу талтай юм.



Судалгааны багийн гишүүд:

Б.Болорбуян ШУС, Биологийн тэнхим 4-р түвшин
Н.Буяннэмэх ШУС, Биологийн тэнхим 4-р түвшин
Г.Өнөржаргал ШУС, Биологийн тэнхим 4-р түвшин
З.Оюунханд БС, 4-р түвшин
Х.Төгсбилэг ШУС, Биологийн тэнхим 4-р түвшин
А. Уламбадрах БС, 4-р түвшин
Б.Хулан ШУС, Биологийн тэнхим 3-р түвшин

Холбоо барих мэдээлэл

МУИС, Номын сан-612 Хүнсний шинжилгээний лаборатори

77307730 – 2490

oyundelgerg@num.edu.mn



ТӨСЛИЙН НЭР: РНХ АГУУЛСАН ВИРУСИЙГ ОНОШЛОХ CRISPR ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТҮРГЭН ОНОШЛУУР

Төслийн удирдагч: Дэд профессор Д.Лхагвасүрэн
ШУС, БУС, Биологийн тэнхим

ТАНИЛЦУУЛГА:

Вирусийн халдварт өвчний тархах зам нь олон янз, хянахад төвөгтэй илрүүлэхэд цаг хугацаа шаардсан өндөр үнэтэй оношилгооны техник ашигладаг учраас нийгэмд хурдацтай тархах нөхцөл болдог. Үүний нэгэн жишээ нь SARS-CoV-2 вирусийн гаралтай КОВИД-19 өвчин бөгөөд уг өвчнийг оношлох нь хянахад тохиолдож буй хамгийн хүндрэлтэй асуудлуудын нэг нь болоод байгаа юм. Тиймээс вирусийг богино хугацаанд өндөр нарийвчлалтайгаар илрүүлэн оношлох нь нэн чухал шаардлагатай, энэ тэргүүнд хийж гүйцэтгэх ажил болоод байна.

CRISPR технологид суурилсан шинэ төрлийн оношлуур нь нуклейн хүчлийн дараалалд өвөрмөцөөр идэвхэждэг уураг бөгөөд Полимеразын Гинжин Урвалтай ижил нарийвчлалтай боловч ПГУ шиг дээжээс нуклейн хүчлийг олшруулахгүйгээр шууд тодорхойлох боломж олгодоггоороо давуу талтай юм. Энэхүү аргыг хөгжүүлэн бүтээгдэхүүн болгосноор РНХ агуулсан ханиад, томуу, галазуу, элэгний гепатитын С вирус, гахайн хавдар, ХДХВ вирус гэх мэт олон төрлийн вирусийн халдварыг хүн болон амьтны гаралтай дээжид түргэн хугацаанд мэдрэг болон өвөрмөц чанар өндөртэйгөөр оношлон тодорхойлох боломжтой юм.



Вирусийг богино хугацаанд өндөр нарийвчлалтайгаар илрүүлэн оношлох нь нэн чухал тул энэ тэргүүнд хийж гүйцэтгэх ажил болоод байна.



Судалгааны багийн гишүүд:

Ч. Мөнгөнсар БУС-Биотехнологи, Докторант
Д. Цэнд-Аюуш БУС-Биотехнологи, Магистрант
Т. Халиун БУС-Биотехнологи, Магистрант
Л. Сугар БУС-Биотехнологи, Бакалавр-IV
Б. Марал БУС-Биотехнологи, Бакалавр-IV
Э. Есүхэй БУС-Биотехнологи, Бакалавр-IV
А. Жанбота БС-Менежмент, Бакалавр-IV

Холбоо барих мэдээлэл

МУИС, Хичээлийн 2-р байр 213в тоот

77307730 – 2419

lkhagvasuren.d@num.edu.mn

ТАНИЛЦУУЛГА:

Манай төсөл нь хүүхэд, залуусыг шинэлэг, сонирхолтой сорилоор амьдралын хэв маягийг нь идэвхжүүлэх инновац бүхий аппликейшн юм. Цар тахлаас үүдэх ойрын 2-3 жилд сэтгэл гутрал, ганцаардал, бухимдал нь залуусын тулгамдсан асуудал болсон төдийгүй яаж ангижрахаа мэдэхгүй дэлгэцэд маш их цагийг зарцуулж байгааг бид анзаарсан. Иймд энэхүү аппаар дамжуулж хөгжөөнтэй, өртөөт болон үе шат бүхий чалленжүүдийг найз нөхөд, хамт олноороо биелүүлэн цагийг идэвхтэй, зугаатай өнгөрөөх боломжтой. Аппликейшн дээр өөрийн бүртгэлийг үүсгэн бидэнтэй нэгдэж сонирхолтой, шагналт даалгавар /челлэнжүүдийг/ биелүүлэн өөрийн аватарыг хөгжүүлэх боломжтой аж. Бид энэхүү төслийн санаагаа 2021 оны хавар гарган тасралтгүй хөгжүүлсээр байгаа бөгөөд одоогоор хөгжүүлэлтийн шатандаа явж байна.



Манай төсөл нь хүүхэд, залуусыг шинэлэг, сонирхолтой сорилоор амьдралын хэв маягийг нь идэвхжүүлэх инновац бүхий аппликейшн юм.

**Судалгааны багийн гишүүд:**

- О.Төгөлдөр ХШУИС, МКУТ - Мэдээллийн технологи - IV
- С.Мөнхням БС - Санхүү менежмент - IV
- Б.Дэлгэрсайхан ХШУИС, МКУТ - Програм хангамж - IV
- Ч.Номин БС - Банк - IV
- Д.Одбилиг БС - Санхүү менежмент - IV
- Т.Ганцогт ХШУИС, МКУТ - Програм хангамж - IV
- А.Дэлгэрсайхан ХШУИС, МКУТ - Програм хангамж - IV

**Холбоо барих мэдээлэл**

МУИС, ХШУИС, Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхим

☎ 86241107

✉ tuguldurchh@gmail.com,
contact@phoenixmn.com





QUICK DROP

ТӨСЛИЙН НЭР: QUICKDROP – ГЭРЭЭТ ТҮГЭЭГЧДЭЭР ХЭРЭГЛЭГЧИЙН БАРААГ ХАМГИЙН НАЙДВАРТАЙГААР ХЯМД ХҮРГЭНЭ.

Төслийн удирдагч: Ахлах багш Ш.Энхтуул
БС, Менежментийн тэнхим

ТАНИЛЦУУЛГА:

"Quickdrop" баг нь хэрэглэгчийн хүсэл сонирхолд нийцсэн бараа хүргэлтийн үйлчилгээг орчин үеийн технологи, гар утасны аппликейшнээр дамжуулан уян хатан нөхцөлөөр хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэх төсөл юм. Түлхүүр үйл ажиллагааны хувьд аппликейшнээр өөрт хамгийн ойр буй түгээгчээр дамжуулан бага болон дунд оврын ачаагаа өдөртөө хүргүүлэх зорилготой. Хувьдаа машинтай жолоочдын сүлжээ нь бидний хамгийн том нөөц юм. Мөн 30 минут тутам шинэчлэгддэг, Real-Time tracking хэрэглэгчид бараагаа хаана явааг харах боломжтой газрын зураг нь чухал нөөц юм.

Quickdrop нь олон талт платформ бөгөөд хэрэглэгч, түгээгч аль аль талд нь үнэ цэн бий болгоход гол утга оршино. Хэрэглэгчид бид "Гэр бүл, найз нөхдөөс тань ч илүү найдвартай, түргэн шуурхай чухал барааг тань хүргэж үйлчилнэ" гэсэн сэтгэл ханамжийн баталгааг өгнө. Манай үйлчилгээ нь Premium буюу өндөр үнэ бүхий болон fragile ачааг хүргэх, Express буюу хамгийн богино хугацаанд ачаагаа хүргүүлэх, Regular буюу онцгой нөхцөл заагаагүй ачааг хүргэх гэсэн гурван төрлийн нөхцөлт үйлчилгээний сонголтыг олгох болно. Мөн дээрх гурван төрлийн үйлчилгээгээр үнийн нөхцөл ялгаатай байна.



Хэрэглэгчийн хүсэл сонирхолд нийцсэн бараа хүргэлтийн үйлчилгээг орчин үеийн технологи, утасны аппликейшнээр дамжуулан уян хатан нөхцөлөөр хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэх төсөл юм.



Судалгааны багийн гишүүд:

Б.Жавхлан БС, Төгсөгч
Г.Мөнхцэнгэл БС, Бакалавр
Э.Номин БС, Бакалавр
А.Цэвэгмэд БС, Бакалавр

Холбоо барих мэдээлэл

МУИС, БС, Менежментийн тэнхим

☎ 77307730 – 4117

✉ enkhtuuls@num.edu.mn





ТӨСЛИЙН НЭР: САГСАА ЧОНЫН ӨРГӨС УРГАМЛААР НИЙЛЭГЖҮҮЛСЭН МӨНГӨНИЙ НАНОБӨӨМ АГУУЛСАН ҮРЭВСЛИЙН ЭСРЭГ ШАРХНЫ ТОС

Төслийн удирдагч: Дэд профессор Ө.Энэрэлт
ШУС, БУС, Биологийн тэнхим

ТАНИЛЦУУЛГА:

"Tradinsight" баг нь Монгол улсын их сургуулийн биологийн тэнхимийн багш оюутнуудаас бүрдсэн. Монгол улсын хувьд үрэвсэлт шархны эсрэг эмчилгээнд дийлэнх нь импортын эмийн бүтээгдэхүүнийг хэрэглэдэг. Манай баг ургамлаар нийлэгжүүлсэн мөнгөний нанобөөмийн шинж чанар биологийн идэвхийн судалгааг хийж, бактери үрэвслийн өндөр идэвхт мөнгөний нанобөөм гарган авч чадсан.

Нанотехнологи олон салбарт нэвтэрснээр шинэ инновац, хөгжлийг бий болгож байна. Олон улсын судлаачид металлыг нано хэмжээтэй (10-9 м) нийлэгжүүлснээр бактери, вирус, хавдрын эсийг устгах чадвартайг тогтоосон. Тиймээс эмнэлэг, гоо сайхан, хоол хүнс технологийн салбарт нано хэмжээт металлуудыг хэрэглэх боломжтой. Бид ногоон технологи болох ургамал ашиглан мөнгөний нанобөөм нийлэгжүүлж байгаа учраас байгаль орчинд хорт хаягдалгүй, хоруу чанар багатай, өртгийн хувьд хямд үйлдвэрлэлийн процесс явуулах бүрэн боломжтой.

Тосны түүхий эдээр хонины сүүлэн тос, эмийн ургамал ашиглан мөнгөний нанобөөм нийлэгжүүлж байгаа тул манай бүтээгдэхүүн нь бусад эмийн бүтээгдэхүүнтэй харьцуулахад хүнд сөрөг нөлөө багатай. Бид шинжлэх ухааны салбарт үндэслэж чанартай, өндөр үр дүн бүхий эмчилгээний бүтээгдэхүүнийг эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага болон хүн ардаа хүргэхээр ажиллаж байна.



Бидний санаачилж буй төсөл нь үрэвслийн эсрэг идэвхт мөнгөний нанобөөмөөр биологийн идэвхт бүтээгдэхүүн гарган авах, тэр дундаа шархны эмчилгээний тосон түрхлэг болон коллагенттай шархны наалт зэргийг үйлдвэрлэж эмийн зах зээлд нэвтрүүлэхэд оршино.



Судалгааны багийн гишүүд:

Г. Аминаа МУИС, ШУС, Биологийн тэнхим Магистрант
С. Номинчимэг МУИС, ШУС, Биологийн тэнхим Магистрант
Б. Энхдэлгэр МУИС, ШУС, Биологийн тэнхим Магистрант
Б. Алтанзул МУИС, ШУС, Биологийн тэнхим Бакалавр
Т. Дүүрэнжаргал МУИС, ШУС, Биологийн тэнхим Бакалавр

Холбоо барих мэдээлэл

МУИС, Хичээлийн байр 2-122

☎ 77307730-2425

✉ enerelt@num.edu.mn



ТӨСЛИЙН НЭР: ОЙН ДАГАЛДАХ ТҮҮХИЙ ЭДИЙГ БОЛОВСРУУЛЖ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ

Төслийн удирдагч: Профессор Ш. Наранмандах
ШУС, БУС, Химийн тэнхим

Профессор Ц.Батчулуун

ХШУИС, Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхим

ТАНИЛЦУУЛГА:

Одоогийн байдлаар Монгол оронд ойн биомасс, ойн дагалдах түүхий эдийг иж бүрэн ашиглаж чадахгүй байна. Тухайлбал, ойн түймэр, хортон шавж, өвчинд нэрвэгдсэн модод болон модны шилмүүс, мөчир, гишүү зэрэг нь ашиглагдахгүйгээр хаягдаж байна. Энэхүү хаягдаж байгаа ойн дагалдах түүхий эдийг боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулж, бүтээгдэхүүн болгон хэрэглэгчдэд хүргэх нь бидний зорилго юм. Манай баг ойн дагалдах түүхий эдийг боловсруулж, эфирийн тос, малын витаминт тэжээл, малын эрдэст тэжээл, биеүүрс гэсэн 4 төрлийн бүтээгдэхүүн гарган авахаар ажиллаж байна.



Ойн дагалдах түүхий эдийг боловсруулж, эфирийн тос, малын витаминт тэжээл, малын эрдэст тэжээл, биеүүрс гэсэн 4 төрлийн бүтээгдэхүүн гарган авах төсөл юм



Судалгааны багийн гишүүд:

- Г. Хулан БУС. Химийн тэнхимийн магистрант
- Б. Даваадулам БУС. Биологийн тэнхимийн магистрант
- Х. Билэгт ХШУИС. Ойн инженерчлэлийн тэнхимийн магистрант
- Д. Энх-Үйлс БУС. Химийн тэнхимийн бакалавр
- А. Эвэлэн-Эгшигт БС. Менежментийн тэнхимийн бакалавр

Холбоо барих мэдээлэл

МУИС-ийн Хичээлийн 2-р байр 119 тоот

☎ 77307730 – 2435

✉ smandakh@num.edu.mn,
batchuluun@num.edu.mn

